**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Аудитын код: ХОА-2022/155/НА-СТА-ТШ3

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Ховд хот<br>2023 он | Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар<br>Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn<br>Аудитын менежер: А.Цэцэгсүрэн<br>Утас:70432545<br>Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn<br>Аудитор: С.Оюунжаргал<br>Утас: 99911390<br>Цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** 3-4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ......5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ......13

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ......13

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ......13

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ......13

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ......14

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ......15

**3.5.1 Төсвийн төлөвлөлт** ......15

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл** ......15

**3.5.3 Нэмэлт төсөв** ......15

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ......16

**4.1 Ерөнхий зүйл** ......16

**4.2 Материаллаг байдал** ......16

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ......16

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** ......16

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ......16

**4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн** ......17

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ......17

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ......19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ДЭМБ | Дэлхийн эрүүл мэндийн байгууллага |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |

МЯНГАД СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА Ж.ЭНХЧУЛУУН ТАНАА

**ХОВД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.24 № 02/75

танай ____________-ны №______________-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Аудитаар Эрүүл мэндийн төвийн 90 жилийн ойн арга хэмжээний хандивын орлогыг бэлнээр авч зарцуулсан, байгууллагын данс бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу хандивын зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтан шагналд байгууллагын төсвөөс мөнгөн шагнал дагалдуулж олгосон 25.7 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийтийн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоол АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн төв нь урьд жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлэг буюу улсын төсвөөс шууд санхүүждэг байсан ба тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар санхүүждэг болсон байна. Ингэснээр нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

2022 онд нийт 6648 иргэдэд амбулаторийн үзлэг хийж 399 үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмчилж 2671 ор хоног, дундаж ор хоног 6.7 байна.Тус байгууллага нь тайлант онд 8

021020357

зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 40 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 93.4 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **74,934,278.13** | **115,146,970.93** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 52,358.00 | 54,034,496.15 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 52,358.00 | 54,034,496.15 |
| **3121** | **Төгрөг** | 52,358.00 | 54,034,496.15 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 52,358.00 | 54,034,496.15 |
| **33** | **АВЛАГА** | 27,973,172.95 | 4,492,450.05 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,045,094.95 | 1,301,295.95 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 26,643,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 285,078.00 | 3,191,154.10 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 3,191,154.10 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 285,078.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 46,908,747.18 | 56,620,024.73 |
| **351** | **Түүхий эд материал** | 17,118,204.00 | 26,859,282.90 |
| 35130 | Эм боох материал | 17,118,204.00 | 26,859,282.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 29,790,543.18 | 29,760,741.83 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 810,500.00 | 1,268,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,548,743.18 | 22,144,741.83 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,595,000.00 | 3,595,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 186,000.00 | - |
| 35460 | Хүнсний материал | 650,300.00 | 2,752,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **430,553,936.84** | **558,008,379.46** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 430,553,936.84 | 558,008,379.46 |
| **392** | **Биет хөрөнгө** | 419,372,136.84 | 546,946,579.46 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 392,736,940.00 | 415,681,840.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (39,378,757.96) | (51,556,677.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 48,768,956.00 | 105,625,620.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (35,159,729.86) | (40,115,802.22) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 98,459,352.18 | 170,859,360.18 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (63,993,367.58) | (70,560,397.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,025,517.73 | 42,025,781.73 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (22,166,773.67) | (25,093,145.47) |
| 39217 | Ном | 80,000.00 | 80,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 11,181,800.00 | 11,061,800.00 |
| 39301 | Програм хангамж | 1,725,000.00 | 1,725,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (525,000.00) | (645,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,981,800.00 | 9,981,800.00 |
| **394** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **505,488,214.97** | **673,155,350.39** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **39,052,605.40** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 39,052,605.40 | - |
| **413** | **Өглөг** | 39,052,605.40 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 883,128.40 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 38,169,477.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **466,435,609.57** | **673,155,350.39** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 466,435,609.57 | 673,155,350.39 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 159,985,026.00 | 159,985,026.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (113,116,520.15) | 93,603,220.67 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (113,116,520.15) | (113,116,520.15) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 206,719,740.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 419,567,103.72 | 419,567,103.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **505,488,214.97** | **673,155,350.39** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **624,270,974.44** | **843,693,860.80** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **428,739,314.44** | **170,396,730.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 22,813,414.44 | 170,396,730.80 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 22,813,414.44 | 170,396,730.80 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 22,813,414.44 | 170,396,730.80 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 405,925,900.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 405,925,900.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **195,531,660.00** | **673,297,130.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 112,137,902.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 111,814,902.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 323,000.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,208,700.00 | 30,523,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,208,700.00 | 30,523,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 63,185,058.00 | 642,773,330.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 63,185,058.00 | 642,773,330.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **639,228,097.12** | **636,974,119.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **638,864,559.44** | **636,974,119.98** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 607,864,559.44 | 633,067,069.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 364,553,274.05 | 394,941,663.00 |
| 210101 | Үндсэн цалин | 197,634,825.70 | 253,529,962.00 |
| 210102 | Нэмэгдэл | 135,407,782.47 | 96,448,791.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,088,998.80 | 5,333,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,421,667.08 | 39,629,910.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 46,601,928.09 | 49,116,318.35 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,159,828.09 | 34,296,775.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,360,500.00 | 3,949,416.63 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,688,400.00 | 3,159,533.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 293,604.75 | 700,963.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,099,595.25 | 7,009,630.34 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,474,700.00 | 25,558,750.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,938,192.00 | 1,556,750.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,036,508.00 | 18,502,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,256,167.67 | 50,145,906.35 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,616,200.00 | 4,346,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,856,205.00 | 24,912,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,906,200.00 | 1,472,280.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000.00 | 3,850,740.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 1,124,900.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 8,377,562.67 | 11,558,395.90 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 2,880,495.45 |
| **2105** | **Нормативт зардал** | 113,329,072.00 | 74,318,158.90 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 101,832,662.00 | 59,188,768.90 |
| 210502 | Хоол, хүнс | 9,496,410.00 | 15,129,390.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,228,600.00 | 1,139,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,228,600.00 | 1,139,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 350,000.00 | 4,010,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 4,010,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 910,600.00 | 2,715,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 695,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 83,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 425,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 25,000.00 | 73,280.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 9,500.00 | 29,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 253,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 376,100.00 | 1,156,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 30,160,217.63 | 31,121,793.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,184,500.00 | 4,374,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 26,975,717.63 | 26,747,393.38 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 31,000,000.00 | 3,907,050.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,000,000.00 | 3,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,000,000.00 | 3,200,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 707,050.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 707,050.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **363,537.68** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 363,537.68 | - |
| 225101 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) /ТӨҮГ/ | 363,537.68 | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(14,957,122.68)** | **206,719,740.82** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(14,957,122.68)** | **206,719,740.82** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **576,055,602.00** | **699,940,130.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **576,055,602.00** | **699,940,130.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 405,925,900.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 113,378,944.00 | 360,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 113,055,944.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 323,000.00 | 360,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 20,208,700.00 | 30,523,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,208,700.00 | 30,523,800.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 36,542,058.00 | 669,056,330.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 36,542,058.00 | 669,056,330.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **576,003,244.00** | **645,957,991.85** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **576,003,244.00** | **645,957,991.85** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **545,003,244.00** | **642,050,941.85** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 364,847,097.00 | 392,670,143.07 |
| 210101 | Үндсэн цалин | 197,928,648.65 | 221,291,092.33 |
| 210102 | Нэмэгдэл | 135,407,782.47 | 120,964,928.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,088,998.80 | 6,765,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,421,667.08 | 43,649,122.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 45,617,100.00 | 47,100,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,175,000.00 | 32,487,004.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,360,500.00 | 3,661,635.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,688,400.00 | 2,939,148.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 293,604.75 | 728,328.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,099,595.25 | 7,284,483.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,480,600.00 | 25,558,750.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,938,192.00 | 1,556,750.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,042,408.00 | 18,502,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,657,805.00 | 37,738,525.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,132,400.00 | 4,841,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,119,205.00 | 25,156,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,906,200.00 | 1,472,280.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000.00 | 3,949,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 2,318,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 73,766,942.00 | 112,792,006.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 63,766,942.00 | 95,560,406.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 8,000,000.00 | 15,683,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,000,000.00 | 1,547,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,307,600.00 | 5,535,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,479,500.00 | 2,308,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 750,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,828,100.00 | 2,476,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 350,000.00 | 4,010,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 350,000.00 | 4,010,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,110,600.00 | 4,721,850.85 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 2,637,350.85 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 200,000.00 | 83,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 300,000.00 | 425,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 25,000.00 | 90,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 9,500.00 | 29,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,576,100.00 | 300,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 1,156,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6,865,500.00 | 11,924,066.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,865,500.00 | 11,924,066.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,000,000.00** | **3,907,050.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,000,000.00 | 3,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 31,000,000.00 | 3,200,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 707,050.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 707,050.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **52,358.00** | **53,982,138.15** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 52,358.00 | 53,982,138.15 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 52,358.00 | 54,034,496.15 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C01** | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **(98,159,397.47)** | **481,392,732.25** |
| **C02** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **C03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **(98,159,397.47)** | **481,392,732.25** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **C07** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **-14,957,122.68** | **(14,957,122.68)** |
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **(113,116,520.15)** | **466,435,609.57** |
| **D01** | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **(113,116,520.15)** | **466,435,609.57** |
| **D02** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **(113,116,520.15)** | **466,435,609.57** |
| **D08** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **206,719,740.82** | **206,719,740.82** |
| **D09** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **159,985,026.00** | **419,567,103.72** | **93,603,220.67** | **673,155,350.39** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 693,660,300.00 | 645,250,941.85 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 693,660,300.00 | 645,250,941.85 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 690,460,300.00 | 642,050,941.85 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 393,219,300.00 | 392,670,143.07 |
| 210101 | Үндсэн цалин | 227,889,600.00 | 221,291,092.33 |
| 210102 | Нэмэгдэл | 124,821,700.00 | 120,964,928.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,744,000.00 | 6,765,000.00 |
| 210104 | Урамшуулал | 33,764,000.00 | 43,649,122.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 47,100,600.00 | 47,100,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,491,700.00 | 32,487,004.62 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,990,400.00 | 3,661,635.60 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,402,200.00 | 2,939,148.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 599,000.00 | 728,328.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,617,300.00 | 7,284,483.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 26,265,800.00 | 25,558,750.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,263,800.00 | 1,556,750.00 |
| 210302 | Түлш, халаалт | 18,502,000.00 | 18,502,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,500,000.00 | 5,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 43,850,700.00 | 37,738,525.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,872,500.00 | 4,841,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,345,000.00 | 25,156,795.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,794,500.00 | 1,472,280.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,949,800.00 | 3,949,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,888,900.00 | 2,318,050.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 138,882,800.00 | 112,792,006.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 119,915,500.00 | 95,560,406.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,133,800.00 | 15,683,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,833,500.00 | 1,547,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,292,600.00 | 5,535,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,416,500.00 | 2,308,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,400,000.00 | 750,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,476,100.00 | 2,476,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,024,000.00 | 4,010,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,024,000.00 | 4,010,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 9,228,200.00 | 4,721,850.85 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,666,700.00 | 2,637,350.85 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 533,500.00 | 83,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 452,000.00 | 425,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,500.00 | 90,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 29,000.00 | 29,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 300,000.00 | 300,000.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,156,500.00 | 1,156,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19,596,300.00 | 11,924,066.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,596,300.00 | 11,924,066.93 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,200,000.00 | 3,200,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 3,200,000.00 | 3,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,200,000.00 | 3,200,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 693,633,300.00 | 699,940,130.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 30,523,800.00 | 30,523,800.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30,523,800.00 | 30,523,800.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 662,749,500.00 | 669,056,330.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 662,749,500.00 | 669,056,330.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 360,000.00 | 360,000.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 360,000.00 | 360,000.00 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | - | - |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | **52,358.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | **54,034,496.15** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 24.00 | 25.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19.00 | 19.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 4.00 | 4.00 |
| **64** | **ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО** | - | 7,047.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **25.00** | **25.00** |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 19.00 | 17.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 1.00 | 1.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мянгад сумын Эрүүл мэндийн төв нь Иргэн бүрийг эрт илрүүлэг үзлэгт хамруулах, үйлчлэх хүрээний хүн амд эрүүл мэндийн анхан шатны болон нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд, тасралтгүй, чанартай хүртээмжтэй үзүүлснээр хүн амын өвчлөл эндэгдлийг бууруулах эрхэм зорилгыг тодорхойлжээ.

Мянгад сумын эрүүл мэндийн төв нь нийт 23 ажилтан албан хаагчидтай эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд эмчлэх, сувилах эрхийн зөвшөөрөлтэй. Их эмч-2, Багийн эмч-2, Сувилагч-4, Дүн бүртгэгч бага эмч-1, Эх баригч -1, Нийгмийн эрүүл мэндийн ажилтан-1, Ахлах сувилагч -1, Вакцинатор -1, Нягтлан бодогч -1, Эм зүйч -1, Лаборант -1, Туслах ажилчид-7 орон тоотойгоор эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлэн 2 орон тоо дутуу ажиллаж байна.

Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах жил болгон зарласантай холбогдуулан тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааг зорилго болгон ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.Үүнд:

- *Засгийн газрын 2022оны 107 дугаар тогтоолоор "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай "*

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мянгад сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 166.6 сая төгрөгөөр буюу 33 хувиар өссөн нь ЭМЯ, ДЭМБ, ЭМГ, ОНХС-аас үнэ төлбөргүй орлого хүлжээж авсантай холбоотой байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.052 | 54.04 | 53.9 |
| Авлага | 27.9 | 4.5 | (23.4) |
| Бараа материал | 46.9 | 56.6 | 9.7 |
| Үндсэн хөрөнгө | 430.5 | 558.0 | 127.5 |
| **Нийт хөрөнгө** | **505.5** | **673.1** | **166.6** |
| Өр төлбөр | 39.0 | - | (39.0) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 466.4 | 673.1 | 206.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **505.5** | **673.1** | **167.6** |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Байгууллага нь гүйцэтгэлээр санхүүждэг болсны дагуу Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 54.04 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Өмнөх онд аймгийн эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 26.6 сая төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулсан. Тайланд онд үлдэгдлээр тайлагнасан 4.5 сая төгрөгийн авлага нь ажиллагсдаас авах авлага татварын байгууллагад илүү шилжүүлсэнтэй холбоотой өөрчлөлт орсон байна.
- ✓ Бараа материал 9.7 төгрөгөөр өссөн нь гүйцэтгэлээр санхүүжилт авч байгаатай холбоотой 3 сарын эмийн нөөц бүрдүүлсэн, тайлант хугацаанд Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй 14.0 сая төгрөгийн бараа материал, хандиваар 4.8 сая төгрөгийн бараа материалууд хүлээн авсан холбоотой байна.
- ✓ 2022 онд төсвийн хөрөнгөөр 1.8 сая төгрөгийн өнгөт принтер 2 ширхэг , ОНХС-аас 22.1 сая төгрөгийн барилгын засвар үйлчилгээ, Эрүүл мэндийн газраас 19.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ДЭМБ-аас зөөврийн компьютер, иж бүрэн зөөврийн эхо

аппарат, пад, аймгийн ЗДТГ-аас 13.0 сая төгрөгийн мотоцикл, компьютер, Эрүүл мэндийн яамнаас 78.9 сая төгрөгийн Эхо аппарат, фургон машин гэх мэт хөрөнгүүд нэмэгдэж элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 30.5 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 663.1 сая төгрөг бүгд 693.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж 693.6 сая төгрөгөөр баталсан.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлд суурилсантай холбоотой эрүүл мэндийн даатгалын сангаас 669.3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 30.5 сая төгрөг нийт 699.1 сая төгрөгийн санхүүжилт авч 645.3 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулж 53.8 төгрөгийг хэмнэж ажилласан байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/сая төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71602/80302-нэг иргэнд ногдох норматив | 347.7 | 343.1 | 4.6 | 98.7 |
| 2 | 71602/81603-Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ | 271.3 | 222.1 | 49.2 | 81.9 |
| 3 | 71602/83603-дээд шатны төсвөөс хуваарилсан | 50.3 | 50.3 | - | 100.0 |
| 4 | 71602/80111-тогтмол зардал | 26.8 | 26.8 | - | 100.0 |
| 5 | 71602/80112-нийтлэг үйлчилгээ | 3.0 | 3.0 | - | 100.0 |
| | **ДҮН** | **699.1** | **645.3** | **53.8** | **95.2** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн тайлангийн жилд нэмэлтээр орлого, зарлагын гүйлгээ гараагүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 02 дугаар сарын 24–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 13 албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 638.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр тогтоосон байсныг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар буюу 9.5 сая төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 7.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээг бүрэн мэдээллэж, төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээллээгүйг аудитын явцад залруулан мэдээлүүллээ.

### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 12.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгөгдөж биелэлтийг 100 хувь ханган ажилласан байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 12.3 | 2 | 12.3 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **12.3** | **2** | **12.3** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцлон анхаарах асуудал аудит хийх явцад эмийн анхан шатны баримт ирүүлээгүй тул анхааран үзэх шаардлагатай гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1 алдаа[1] илэрснээс аудитын явцад 1 алдааг залрууллаа.Үүнд: төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд оруулаагүй системд байршуулж залрууллаа.

Аудитаар нийт 25.7 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 1.47 сая төгрөгийн төлбөрийн акт, 24.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүллээ.

### 5.1 Төлбөрийн акт

- ✓ Эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан байгууллагын албан хаагчдад 433.1 мянган, дотоод аудитаар тавигдсан 256.1 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн, Татварын хэлтэс рүү 786.9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 " Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

- ✓ Эрүүл мэндийн төвийн 90 жилийн ойн арга хэмжээний хандивын орлогыг бэлнээр авч зарцуулсан, байгууллагын данс бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу хандивын зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй 24.7 сая төгрөгийн зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д ''Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" 17.3-т "Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.3 Зөвлөмж**

***5.3.1 Цалин хөдөлмөрийн хөлстэй холбоотой***

***Илрүүлэлт:*** Байгууллагын даргад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо нэмэгдэл хөлс тооцох маягтыг томилсон эрх бүхий тушаалтнаар хянуулж батлуулаагүй, зөрчил нь Засгийн газрын 382 тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар зүйлийн 1 " Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***Өгсөн зөвлөмж** :Засгийн газрын тогтоол баримтлан илүү цагийн нэмэгдэл хөлс олгож хэвших,*

**5.3.2 Урсгал зардалтай холбоотой**

***Илрүүлэлт*:.** Эдийн засгийн ангилал зөрчиж бусад зардлаас цалингийн зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д ''Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ'' гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байхs

***Өгсөн зөвлөмж:** Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргахгүй байх*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | | | Дүн | Тоо | | Тоо | Дүн |
| Шилэн дансанд Төсөв өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээллээгүй | 1.0 | - | 1.0 | - | - | - | 1.0 | - | - | - | - | - |
| Дүн | 1.0 | - | 1.0 | - | - | - | 1.0 | - | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шагналд төсвөөс мөнгө дагалдуулж олгосон, актын төлбөрийг төсвөөс төлсөн, ХХОАТ-т илүү төлөлт хийсэн | 1 | 1,476.1 | 1 | 1,476.1 | | | | |
| Эрүүл мэндийн төвийн ойн хандвыг бэлнээр авч зарцуулсан, данс бүртгэлд тусгаагүй | 1 | 24,270.0 | | | 1 | 24,270.0 | | |
| Илүү цагийн нэмэгдэл хөлсийг маягтын дагуу олгоогүй | 1 | - | | | | | 1 | - |
| Эдийн засгийн ангилал зөрчиж зардал гаргасан | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 3 | 25,746.1 | 1 | 1,476.1 | 1 | 24,270.0 | 1 | - |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: С.ОЮУНЖАРГАЛ

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2023 оны 02 сарын 24 өдөр Дугаар 14/2170430 Ховд

ХОА-2022/155/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Эрүүл мэндийн төвийн 90 жилийн ойн арга хэмжээний хандивын орлогыг бэлнээр авч зарцуулсан, байгууллагын данс бүртгэлд тусгаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу хандивын зарцуулалтад тавих хяналт хэрэгжүүлээгүй 24.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т "Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно" 17.3-т "Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.4-т "Төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх", Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-т "Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ойн арга хэмжээний хандивын орлого зарлагын зарцуулалтад дотоод хяналтын баг томилон хяналт хэрэгжүүлж тайланг олон нийтэд мэдээллэж биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэх

2. Цаашид алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Энхчулуун нягтлан бодогч Д.Баярмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

*ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР* *Х.БОЛДБААТАР*

*АУДИТОР* *С.ОЮУНЖАРГАЛ*

[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

**ХОВД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2023 оны 02 сарын 24 өдөр     Дугаар 29/2170430     Ховд

ХОА-2022/155/НА-СТА-ТШЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар Эрүүлийг хамгаалах тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнагдсан байгууллагын албан хаагчдад 433.1 мянган, дотоод аудитаар тавигдсан 256.1 мянган төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн, Татварын хэлтэс рүү 786.9 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д ''Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ'' Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.3 "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 1.7 " Төрийн албан хаагчид энэ журамд заасан мөнгөн шагналаас бусад шагнал олгоход мөнгө дагалдахгүй" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв,санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж зааснدر үндэслэн **ТОГТООХ нь**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1476.1 мянган төгрөг / нэг сая дөрвөн зуун далан зургаан мянга нэг зуун/-ийг бусад нэр зааж ангилагдаагүй орлогын төрийн сан банкны 100160000955 тоот дансанд 2023 оны 06 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн дарга Ж.Энхчулуун , нягтлан бодогч Д.Баярмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН :**

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР     Х.БОЛДБААТАР

АУДИТОР     С.ОЮУНЖАРГАЛ

0210Г0039